



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/515

Булган сум

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/40 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүн амын сангийн төсөл, хөтөлбөрөөс санхүүжигдэх аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Түр хамгаалах байрны дэргэд “Өвлийн хүлэмж” барих ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “Алтынсапа” ХХК-тай 55,000,000 (тавин таван сая) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (Т.Баярбат)-т олгосугай.

2.Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг), Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (Т.Баярбат)-т үүрэг болгосугай.

3.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Алтынсапа” ХХК-ийн захирал (М.Кумис)-д даалгасугай.

4.Хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж, хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтанд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

06323010529

Аймгийн Засаг даргын 2023 оны
06. дугаар сарын 28-ны өдрийн
А/515...дугаар захирамжийн хавсралт

№	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	Ажил хийсний дараах баталгаат засварын хугацаа	2 жил	Т.Баярбат
2	Алданги	Хоногт гүйцэтгээгүй үүргийн дүнгийн 0.1 хувь байна. Нийт алдангийн хэмжээ гэрээний үнийн дүнгийн 10 хувиас ихгүй байна.	Т.Баярбат
3	Ажил гүйцэтгэх хугацаа	70 хоног	Т.Баярбат